

МЭДЛЭГИЙН ҮНЭНИЙ ТУХАЙ МОНГОЛЧУУДЫН УЛАМЖЛАЛТ ҮНЭЛЭМЖ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

И.Бүрэн-Өлзий Ховд Их Сургуулийн НУТ-ийн эрхлэгч, доктор /Ph.D/, дэд проф.

Түлхүүр үг: Зүйр цэцэн үг, мэдлэг, үнэн ба худал, мэдлэгийн туйлын ба харьцангуй шинж, үнэний шалгуур.

Товч утга: Энэхүү илтгэлд монголын ард түмний ертөнцийг үзэхүйн үзэл санааны цогц илэрхийлэл болсон ардын зүйр цэцэн үгсэд танин мэдэхүйн үзэл сэтгэлгээний тусгал, мэдлэгийн үнэн худал шинж, түүний уг сурвалж, танин мэдэхүйн түвшин, үнэн ба худал мэдлэгийн шалгуурын тухай олон талт асуудлууд хэрхэн илэрч буйг авч үзэхийг зорив.

Мэдлэгийн тухай сургаал нь гүн ухааны нэг үндсэн асуудал юм. Монголын ард түмний ертөнцийг үзэх үзэл санааны нэгэн цогц илэрхийлэл болсон ардын зүйр цэцэн үгийн дотор мэдлэгийн үнэн, худал шинжийн учир холбогдол бүхий үзэл санаа цөөнгүй буй бөгөөд чухам тэндээс л ард түмний танин мэдэхүйн сэтгэлгээний хөгжлийн үйл явц хэрхэн боловсорч ирсэн хийгээд тэдний ертөнцийг танин мэдэх мэдлэгийн түвшин, танин мэдэхүйн үндсэн эх сурвалж юу болох, үнэн мэдлэг түүний шалгуурын тухай гэх мэтийн олон талт асуудлууд хэрхэн тусгагдаж байсныг тодруулан гаргах боломжтой юм. Манай ард түмний ертөнцийг танин мэдэх үйл явц нь урт удаан хугацааны туршид боловсронгуй болон хөгжиж ирсэн бөгөөд юмсын зүй тогтол, жам ёсыг ойлгон ухаарах нь тийм ч амар хялбар биш гэдэг нь ч ойлгомжтой. Чухам олон зуун жилийн амьдралын үйлдэл, үйл ажиллагааны явцад танин мэдсэн мэдлэг ухааныхаа ачаар чухам юуг үнэн, юуг худал гэж үзэх түүний шалгуурыг хэрхэн үнэлэх тухайд ард түмний ертөнцийг ойлгохуйн үзэл ухамсар төлөвшиж ирсэн гэж үзэж болно.

Танин мэдэхүй нь доороос дээдэд, энгийнээс нарийн төвөгтэй рүү бага мэдлэгээс илүү өргөн мэдлэгт шилжих замаар явагддаг. Энэхүү танин мэдэхүйн нарийн нийлмэл үйл явцын талаар ардын зүйр цэцэн үгэнд илэрхийлсэн нь цөөнгүй бий. Хүн юмыг танин мэдэхдээ эхлээд мэдэрч танин мэдэхүйн шат буюу сэрлийн эрхтний тусламжтайгаар хүртэн тусгаж авдаг. Тухайлбал;

Үзсэн нь далай
Үзээгүй нь балай /7-7450/
Үзэхгүй бол танихгүй
Сонсохгүй бол мэдэхгүй /7-7465/
Үзэм бурам амттай боловч
Идэхгүй бол мэдэхгүй
Ухаан санаа сайн боловч
Үзэхгүй бол мэдэхгүй /7-7462/
Үзэх нүдний цэцгий
Үнэрлэх хамрын заар /7-7466/
Үзэхэд нүд сайн
Үнэрлэхэд хамар сайн
Сонсоход чих сайн /8-7469/
Нүдний хүчээр (хурцаар)

Алсын бараа харах
Чихний хүчээр (сонороор)
Холын чимээ сонсох /7-4450/

Нүдээрээн харж ойлгох

Гараараан барьж таних /7-7469/ хэмээх зүйр цэцэн

үгүүдэд танин мэдэхүйн анхдагч элемент нь сэрэл бөгөөд түүгээр дамжин хүний танин мэдэхүйн үе шат явагддаг гэдгийг илэрхийлжээ. Чухамдаа сэрэл бол юмс үзэгдлийг шууд хүлээн авдаг анхдагч элемент төдийгүй чингэхдээ зөвхөн тухайн тодорхой юмсын өнгөн гадаад талыг тусгай байдлаар тусган авдаг онцлогтой. Мөн тэдгээрт сэрлийн эрхтнүүдийн (харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүрэлцэх) ялгаатай тал, онцлогийг тодорхой заан гаргасан байна. Тухайлбал;

Сохор нохой дүйвээнээр, Соотон халтар чимээнээр /7-5967/

Уг зүйр цэцэн үгэнд *сохор-соотон*, *дүйвээнээр-чимээнээр* гэх зэргээр гадаад хэлбэрийн зохицолдоо байгаа төдий биш түүнчлэн өөрийн үзэл бодлоор биш бусдын хэлж ярихаар баримжаалан явагчдыг шоолсон санааг хоёр нохойн дүрээр илтгэжээ. Энэ нь түүний бүтцийн тал юм.

Нөгөө талаас нь аваад үзвэл харьцуулж буй уг ойлголтоороо дамжуулаад хүнийг илэрхийлэх, ойлгуулах, хүмүүжүүлэх утга оршиж байна. Түүнчлэн мэдрэхүйн эрхтэний ялгаатай тал, хүртэгдэх байдлыг эсрэг тэсрэг талуудын харьцаагаар дамжуулан гаргаж өгчээ. Цаад утгыг задлан үзвэл, харах, сонсох эрхтний ертөнцийг тусгах онцлог, амьд амьтны амьдралын хэмнэлд гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн шүтэлцээний тухай, тэхдээ тэдгээрийг шүтэлцүүлсэн бус өрөөсгөл үүргийн тухай өгүүлсэн байна. Чухамхүү харах, сонсох эрхтэн нь зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг талууд болох тухай, тэдгээрийн шүтэлцээ алдагдсан, туйлшруулагч тохиолдлыг гүн ухааны хэлээр энгийн ойлгомжтой байдлаар өгүүлжээ. Энд хэдийгээр энгийн үг хэллэгээр уг харилцааг гаргаж буй боловч түүнд гүн ухааны тодорхой утга хураангуйлагдаж байна гэж хэлж болно. Энэ нь түүний агуулгын тал юм. Гэхдээ энэхүү мэдрэхүйн анхдагч шатны мэдлэг нь өрөөсгөл талтай бөгөөд тухайн зүйлийн талаарх бүрэн дүүрэн үнэн зөв мэдлэг байж чадахгүй нь ойлгомжтой. Энэ тухай;

Нүдээр харсан бүхнийг

Үнэнд итгэж болохгүй

Чихээр сонссон бүхнийг

Үнэмшин итгэж болохгүй /7-4464/ хэмээн өгүүлжээ. Хэдийгээр

сэрлийн мэдлэг бодит байдлын шууд тусгал боловч уг зүйлийн тухай гүн гүнзгий мэдлэгийг бий болгодоггүй гэдгийг уг зүйр цэцэн үгээр гаргасан байна. Тийм учраас юмс үзэгдлийн мөн чанар, дотоод холбоо, зүй тогтол, учир шалтгааныг танин мэдэхэд зайлшгүй хийсвэр сэтгэхүй буюу оюун ухааны мэдлэг чухал ажээ. Танин мэдэхүйн хөгжлийн энэ хоёр шат нь харилцан хамаарал бүхий диалектик нэгдэлтэй бөгөөд угтаа мэдрэхүйн мэдлэг дээр суурилж олж авсан мэдлэгээ оюуны хийсвэр сэтгэхүйгээр нэгтгэн дүгнэж гүнзгийрүүлэн танин мэддэг байна.

Чухамдаа танин мэдэхүй бол ил оршиж буй гадаад шинж харилцааг ойлгож мэдэхээс, дотоод харьцангуй, тогтвортой хэлхээ холбоог мэдэхэд шилжих шилжилт юм. Танин мэдэхүйн эцсийн зорилго нь үнэнд хүрэх, үнэнийг танин мэдэх явдал бөгөөд үнэн болон худал гэдгийг хэрхэн ойлгох,

үнэн, худал мэдлэгийн ач тус, хор уршгийн талаар ардын зүйр цэцэн үгүүдэд цөөнгүй өгүүлсэн байдаг.

Манай ард түмэн олон зуун жилийн амьдралынхаа ажиглалт туршлагын явцад олж авсан мэдлэг ухаан дээрээ суурилан үнэний үнэ цэнэ, мөн чанарыг таньсан танилтаа илэрхийлэх болжээ. Тухайлбал;

Сонссон худал

Үзсэн үнэн /6-5956/ гэх зүйр цэцэн үгэнд өөрийн биеэр тулж нүдээрээ үзэж харсан юм эргэлзээгүй баталгаатай үнэн байж болох, харин зөвхөн сонссон юм үнэн худлын алин ч байж болзошгүй гэсэн санааг илэрхийлэх бөгөөд бусдаас сонсохын төдийгөөр хэтрээгүй үнэн мөнийг нь баттай мэдээгүй зүйлийг үнэн хэмээн баталж ярих хэрэггүй гэсэн өнгө аясыг илтгэнэ. Энэ нь аливаа зүйлд хашир хянуур, ул суурьтай, туйлбартай, голч хандахын чухлыг сануулж буй хэрэг юм. Уг зүйр цэцэн үг нь

Мянга дахин чихээрээ дуулснаас

Нэг дахин нүдээрээ үзсэн нь дээр /7-4072/

Дамын үг далан худалтай


Зуурын үг зуун худалтай /6-478/

Сонссоноос үзсэн нь дээр

Сууснаас явсан нь дээр гэх мэт зүйр цэцэн үгүүдтэй ойролцоо утга илэрхийлдэг байна.

Түүнчлэн үнэн худал хоёр нь хүний мэдлэгийн хоёр тал төдийгүй, арга билиг, нэгдэл тэмцлийн зүй тогтолт шинжийг агуулдаг аж. Гүн ухааны үүднээс үзвэл үнэн бол хүний мэдлэг, мэдлэгийн объектод тохирох явдал мөн. Өөрөөр хэлбэл, объектыг яг байгаагаар нь субъектэд мэдүүлдэг мэдлэгийг үнэн гэж ойлгож болно. Нөгөө талаар танин мэдэхүйн үйл явц дандаа үнэнд хүргэдэггүй. Тухайн зүйлийн талаар буруу үзэл, төсөөлөл төөрөгдөл үүсдэг. Төөрөгдөл нь хүний ухамсарт тусгагдсан гадаад ертөнцийн хуурмаг тусгал юм. Түүнийг "худал" хэмээх ойлголтоор томъёолдог. Энэ тухайд: Дутуу ойлговол сохорно гүйцэд ойлговол гэгээрнэ /1-56/ гэсэн зүйр цэцэн үгэнд юмсыг ойлгохуйн хоёр талт харилцан хамаарал тод тусгагджээ. Үүнд, дутуу болон гүйцэд, сохрох болон гэгээрэх нь хэрхэн ойлгохоос хамаарах бөгөөд энэ нь түгээмэл шинжтэй хоёр талт

Мэдлэгийн туйлын болон хавьцангуйн шинж



харилцаа юм. Энд хүний танин мэдэхүйн чадвар боломж нь юмсын уг мөн чанарт хэрхэн нэвтэрч орсноос шалтгаалах ба чухамдаа гүйцэд болон дутуу ойлгосноос хамаараад сохрох буюу гэгээрэх аж. Ингэж үзвэл дутуу буюу гүйцэд ойлгох нь үнэн худлын үндэс, мэдлэгийн хоёр тал болдог байна.

Мөн уг зүйр цэцэн үгийг арга билгийн сэтгэлгээний үүднээс авч үзвэл дутуу болон гүйцэд нь нэг бүхэл зүйлийн хоёр тал бөгөөд "дутуу ойлгох" нь аргын тал нь, "гүйцэд ойлгох" нь билгийн тал болно. Учир нь "гүйцэд ойлгох" нь тухайн юмсын дотоод агуулга бүхий мөн чанарыг нь таньсан танилт тул үнэнд нэвтрэх тулгуур болж өгдөг. Ийм ч учраас гэгээрэхийн шалтгаан нь гүйцэд ойлгосонтой холбоотой аж. Тэгвэл "дутуу ойлгох" нь тухайн зүйлийн гадаад, өнгөц байдлыг өөрөөр хэлбэл, хэлбэрийн тал бүхий үзэгдлийг танин мэдсэн мэдлэгтэй холбоотой болохоор ийм мэдлэг нь төөрөгдлийн шалтгаан болдог байна. Энэ утгаараа аргын тал болно. Ийнхүү дутуу болон гүйцэд ойлгох нь арга билгийн тогтолцоотой бөгөөд тэдгээр нь сохрох, гэгээрэхийн шалтгаан болдгийг илрүүлж гаргаснаараа гүн гүнзгий учир ёсыг өгүүлж байх бөгөөд ийм хамаарал зүйр цэцэн үгийн дотор түгээмэл бий.

Ер нь мэдлэгийн эцсийн зорилго нь үнэнийг танин мэдэх явдал байдаг. Үүнийг зураг №7 дээр тайлбарлая. Энэхүү графикаар ($y=1/x$, координатын хавтгай) юмсын оршин тогтнолын зүй тогтлыг авч үзэж болох бөгөөд "арга билгийн график" хэмээн томъёолж болох юм. Зурагт үзүүлснээр мэдлэгийн үйл явцыг дараахь байдлаар авч үзэж болно. Аливаа юмс түүний дотроос үнэн мэдлэг ч арга билгийн буюу харьцангуй туйлын гэсэн эсрэг тэсрэг тал, шинжийн шүтэн барилдлагат тогтолцоонд оршдог. Үнэний тухай зөв ойлголт нь №7-ийн 1, 2, 3-аар тэмдэглэгдсэн муруй шугаманд байрлана.

1. Мэдлэгийн харьцангуй үнэний тал нь давамгайлсан. Мөн энэ хэсэгт мэдэрч танин мэдэхүйн буюу эмпирик түвшний мэдлэг голлох шинжтэй байж болно.

2. Мэдлэгийн харьцангуй болон туйлын үнэний нэгдэлтэй буюу харилцан шүтэн барилдсан үнэн мэдлэг.

3. Мэдлэгийн туйлын үнэний шинж нь давамгайлах үе. Сэтгэхүйн үүрэг роль голлох шинжтэй байж болно.

4. Мэдлэг бол ямагт харьцангуй, учир нь энэ ертөнцөд тогтвортой юм гэж үгүй, бүх юм байнгад хувьсан өөрчлөгддөг, тиймээс үнэн мэдлэг гэж үгүй бүх юм худал гэж үзэх үзэл ($x=1, t=0$); мэдлэгийн харьцангуйн шинжийг туйлшруулан үзэх үзлийг гүн ухаанд *релятивизм* гэнэ.

5. Мэдлэгийн туйлын шинжийг дагнан үздэг учраас ийм мэдлэг нь бас худал мэдлэг болно. Учир нь нэгэнт л үнэн гэж үзэж байгаа бол тэр нь өөрчлөлт хувиралтгүй, тогтвортой мөнх шинжтэй байх ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл; үнэн бол үнэн л байх ёстой ($t=1, x=0$) хэмээн туйлын үнэний шинжийг туйлшруулан үздэг учраас өрөөсгөл шинжтэй болно.

Энэхүү үнэн худлын зөрчилт хамаарал, ялгаа заагийг;

Үнэн худал хоёр

Дөрвөн хуруу зайтай /6-2029/

Үнэн худал хоёр

Алга дарам зайтай /6-7586/

Үнэн худал хоёр дөрвөн талтай

Өвөл зун хоёр хоёр талтай /6-7587/ хэмээн товч тодорхой

илэрхийлжээ.

Мөн үнэний ач тус, худлын хор холбогдлыг

Үнэн түмэн сайны үндэс

Худал түмэн муугийн туйл /6-7563/

Үнэн сэтгэл өлзийн үүсэл
 Сайн санаа цэнгэлийн эх /6-7561/
 Үнэн юм алд дэлэм
 Үгүй юм мухар сөөм /8-7593/
 Үнэн ачтай
 Худал хочтой /6-7548/
 Үнэн үг сүүн хариутай
 Худал үг сүхэн хариутай /6-7565/
 Үнэн үг үнэ хүрнэ
 Худал үг жин хөнгөрнө /6-7568/
 Үнэн үг хатуу боловч
 Хэтийн амьдралд тустай
 Үнэн үг шар тос
 Худал үг хар ус /6-7575/
 Үнэн үгний
 Үзүүр ширүүн /-7582/
 Үнэн билигтэй
 Худал балагтай /1-24/
 Үнэн үйл үр тариа шиг

Худал мэх хувхай хожуул шиг /6-7584/ гэх мэтээр арвин баялаг утга агуулга бүхий зүйрлэлүүдээр гаргаж өгчээ. Эдгээрт үнэн болзов, сайн үйлийн үндэс. Тийм болохоор түүнийг ариун цагааны бэлгэдэл сүү, шар тостой зүйрлэсэн байх төдийгүй хэдийгээр үнэн үг хатуу ч үйл хэрэг нь "үр тариа шиг" дэлгэрдэг болохоор хэтийн амьдралд ач тустай байдаг гэсэн санааг давхар агуулж байна. Тэгвэл худал нь - муу, буруу бүхний үндэс. Тийм учраас тэр нь "мухар сөөм" төдийхөн явцгүй, амьдралд хор хохирол дагуулдаг болохоор түүнийг "хар ус", "сүх"-тэй зүйрлэсэн байх ба тэр нь ямар ч үнэ хүндгүй болохоор түүнд ахин дэвших зам гэж үгүй тул "хувхай хожуул" мэт өмхөрч дуусах тавилантай гэсэн санааг агуулж байгаа хэрэг юм.

Түүнчлэн үнэний ялагдашгүй шинж, давуу чанарыг ардын зүйр цэцэн үгэнд;

Уулын чинээ харыг
 Туулайн чинээ цагаан дийлдэг /4-3908/ хэмээх энгийн өгүүлэмжээр илэрхийлэх бөгөөд энэ нь
 Үг ялзардаггүй
 Үнэн балардаггүй /6-7358/
 Үнэн ёс зусраас айхгүй
 Үнэн алт галаас айхгүй /6-7552/
 Үнэнээр явбал
 Үхэр тэргээр туулай гүйцнэ /27- 7553/
 Үнэн юм усанд живдэггүй
 Галд ч шатдаггүй /6-7595/

Үнэн нь ирвэл
 Худал нь зайлна /6-7557/ гэх мэт олон зүйр цэцэн үгүүдээр дээрх санааг батлан өгүүлдэг байна

Үнэн худлын шалгуурын асуудал ч ардын зүйр цэцэн үгэнд ямар нэг хэмжээгээр тусгагдсан байдаг. Учир нь ард түмний ертөнцийг ойлгохуйн

танилт нь практик амьдралынх нь мэдлэг туршлага дээр суурилж ирсэн учраас үнэнийг таних шалгуураа ч үүнтэй холбон үзэж иржээ. Тухайлбал;

Үнэн худлыг туршаад үз

Үнээний сүүг саагаад үз /6-7590/

Үнэн худал нь хойноон

Үнээ шар нь хавраан /6-7585/

Туршаагүй байж тухайлахгүй

Шалгаагүй байж чавчихгүй /6-6529/ гэсэн зүйр цэцэн үгүүдэд ямар ч зүйлийн үр дүн нь тодорхой хугацааны дараа жинхэнэ ёсоороо илрэн гардаг гэсэн санааг илэрхийлэх бөгөөд энэ нь алив үйлийн үнэний шалгуур нь улирах цаг, амьдрал практик байдаг гэсэн утгыг агуулдаг аж. Энэ талаар

Үнэн үг урдаан цэгтэй

Худал үг хойноон цэгтэй /6-7567

Үнэн худал сүүлдээн тодордог

Сайн муу аажимдаан ялгардаг /6-7588/

Долоо дахин хэмжиж

Нэг удаа огтол /6-492/ гэх зэрэг зүйр цэцэн үгүүдээр өргөн хэрэглэгддэг байна. Чухамхүү олон зуун жилийн амьдрал практикийн явцад олж авсан мэдлэг нь улирах цаг өнгөрөхийн хэрээр үнэн, худал нь тодордог гэдгийг нотлон өгүүлж байна. Иймээс Мэдлэг амьдралаас ирдэг

Мэргэжил хөдөлмөрөөс гардаг /1-тал-28/

Өндөр богиныг тохойгоор хэмжиж

Үнэн худлыг практикаар /туршлагаар/ шалгадаг /1-тал-34/

гэх мэтээр утга томъёоллын хувьд улам гүнзгийрч иржээ. Энд мэдлэг, мэргэжил бол зүгээр гэнэт бий болчихдог зүйл биш энэ нь яах аргагүй хүний "үйлдэл, практик туршлага" ажил хөдөлмөрийн явцад л бүрэлдэн бий болдог төдийгүй эргээд амьдралаар шалгагдаж байдаг гэсэн гүн ухааны утга санааг гаргаж өгчээ. Ингэхдээ мэдлэг, үйлдэл, үнэн, худал гэсэн ойлголт ухагдахууныг хэрэглэхдээ зүй зохистойгоор ашиглаж чадсанд байгаа юм. Хэдийгээр урд өмнө нь ийм ойлголтуудыг цөөнгүй хэрэглэж ирсэн боловч зүй зохистойгоор хэрэглэх тал дээр учир дутагдалтай байсныг үгүйсгэж болохгүй юм.

Зүйр цэцэн үгэнд ард түмний олон зуун жилийн практик амьдралын үйл явцад үзэгдэл юмсын зүй тогтолт, дахин давтагдах, түгээмэл холбоо хамаарлыг ажиглаж үнэнийг танин мэдсэн мэдлэгийн шинж нь ихэндээ оюун дүгнэлтийн хэлбэрээр илэрхийлэгдсэн байдаг. Доктор, профессор Х.Сампилдэндэв "Зүйр цэцэн үг нь тус бүрдээ орчлонгийн аль нэг нэгж үзэгдлийн ажиглалтаас урган гарч улмаар түүнтэй нэг утга чанартай буюу нэг хэв төлөвийн бүх үзэгдэлд дэлгэрүүлэн хэрэглэж болох үлэмж түгээмэл хуулийн тухай маш хийсвэрлэсэн сэтгэлгээний гүнзгий дүгнэлтийг агуулна"¹ гэсэн буй. Өөрөөр хэлбэл нэгжээс ерөнхийд шилжих замаар дүгнэлт гаргадаг логик сэтгэлгээний энэ арга зүйр цэцэн үгийн утга илэрхийлэгдэх нэг хэлбэр болж байдаг бөгөөд энэ нь ихэнхдээ үнэний илэрхийлэл болдог гэсэн үг. Жишээ нь;

Улаан манан татвал

Салхлахын тэмдэг

Улаан нар гарвал

¹Х.Сампилдэндэв. Монгол аман зохиолын товчоон. УБ.,2002, 24 дахь тал.

Гандахын тэмдэг /6-6802/

Хөх манан татвал

Бороо орохын тэмдэг

Хүйтэн салхи салхилбал

Хяруу унахын тэмдэг /5-10060/

Өглөөгүүр тогоруу дуугарвал

Бороо орохын тэмдэг

Нарнаар зөгий дуугарвал

Дулаан болохын тэмдэг /7-5024/

Борооны түрүүн шороо

Боохойн өмнө хэрээ /7-1336/

Эдгээр зүйр цэцэн үгс нь ард түмний олон зуун жилийн ажиглалт туршилт дээр үндэслэсэн бөгөөд практикаар шалгагдаж нотлогдсон мэдлэгийн шинжийг илтгэж байгаагаараа гүн ухааны учир ёсыг тод гаргажээ. Логик гаргалгааны үүднээс авч үзвэл эдгээр зүйр цэцэн үгүүд нөхцөлт бодомжийн хэлбэрээр томъёологдсон байх бөгөөд үндэслэгээний /А/ үнэн байхаас мөрдлөгөөний /В/ үнэн байх нь гарцаагүй шинжтэй байдаг. (А В) Хэрвээ А —нь үнэн бол В үнэн байна. Тухайлбал; “хөх манан татах”-нь үндэслэгээ /А/ буюу шалтгаан түүнээс үүдээд “бороо орох” —нь мөрдлөгөө /В/ буюу үр дагавар. Энэ нь шалтгаан үр дагаварын хамаарлыг илтгэж байдаг бөгөөд зүйр цэцэн үгийн доторх энэ харьцааг зөв задлан гаргах нь түүний гүн ухааны учир ёсыг нээн илрүүлэхэд ихээхэн чухал юм. Байгаль ертөнцөө ажиглан танин мэдсэн ард түмний мэдлэг ухаан яндашгүй арвин бөгөөд үнэний учир ёс түүнд агуулагдаж байдаг тул туйлын үнэн магадтай юм. Тухайлбал;

Дээл дээр тусах нь ус боловч

Дэлхий дээр буух нь тос /7-2503/

Уг зүйр цэцэн үгэнд нэг л зүйлийн /борооны/ өөр, өөр /дээл, дэлхий/ юмсад үзүүлэх нөлөөллийн ялгаатай тал, эерэг хийгээд сөрөг шинжийг илэрхийлэн гаргажээ. Ингэхдээ уг зүйлийн нөлөөлөл нь тухайн үзэгдэл юмсынхаа адил бусын шинж чанараас хамаараад ус болох уу, тос болох уу гэдэг нь үзэгдэл юмсын харилцан үйлдлийн шинж чанар, тусгалаас шууд хамааралтайг тухайлж, дээл дээр бороо орвол хувцас норгох, чийг нэвтэрч, хүнийг дааруулах, улмаар ханиад хатгалга хүрч болох сөрөг нөлөөтэйг, тэгвэл дэлхий дээр орсон борооны ус нь газрын шим тэжээлийг хангаж, өвс ургамал урган дэлгэрч, улмаар мал сүрэг, амьд бүхэн сэргэн тэнхрэх үндэс, байгаль, дэлхийн өнгө чимэг болдгийг товч бөгөөд гүн утгаар гаргаж өгсөнд оршино.

Ийнхүү ардын зүйр цэцэн үгийн дотор мэдлэгийн хоёр талт шинж болох үнэн, худлын тухай, түүний ач тус, хор холбогдлын тухай, үнэнийг шалгах шалгуурын асуудал төдийгүй амьдралаар таньсан үнэний танилтаа хийсвэрлэхүйн сэтгэмжээр яруу сайхнаар илтгэсэн мэдлэг ухаан арвин баялаг агуулагдаж байдгийг өмнө өгүүлснээс үзэхэд тодорхой байна.

Summary

In this thesis we have studied many-sided problems about reflection of a cognitive point of view in proverbs which became a complex expression of worldview of Mongolians, true and false mark of knowledge, its source, a level of

cognition and criterion of true and false knowledge and, especially how the above-mentioned things are occurring.

НОМ ЗҮЙ

1. Алшаагийн зүйр цэцэн үгс. Алшаа аймгийн соёл түүхийн төв. 1987.
2. Ч.Жүгдэр. Монголын философийн түүхийг судлах арга зүйн зарим асуудал. /Монголын философийн түүхийн зарим асуудал/, УБ.,1990. 7 дахь тал.
3. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ /Хоёр дахь хэвлэл/. УБ.,2002.
4. Монгол цэцэн үгийн далай, I дэвтэр, Эмх. Ж.Дашдорж. Г.Рэнчинсамбуу. ШУАХ, УБ.,1964.
5. Монгол цэцэн үгийн далай, II дэвтэр, Эмх. Ж.Дашдорж. ШУАХ, УБ.,1966.
6. Монгол зүйр цэцэн үгийн гурван мянган дээж. Эмх. Д.Заяабаатар. УБ.,1999.
7. Монгол зүйр цэцэн үг. Тэргүүн дэвтэр, Эмх док, проф. Г.Рэнчинсамбуу. УБ., 2002.
8. Монгол зүйр цэцэн үг. Дэд дэвтэр, Эмх док, проф. Г.Рэнчинсамбуу. УБ., 2002.
9. Х.Сампилдэндэв. Монгол аман зохиолын товчоон. УБ.,2002